

“НЭГ БУС, НЭГ ЗАМ” САНААЧИЛГЫН ГЕОПОЛИТИКИЙН СТРАТЕГИ

*Ц.Буянцогтоо**

***Abstract:** The research is about geopolitical strategy of “One belt, One road” initiative proposed by China. The strategy behind China is giving a great importance to the event is to ensure its energy security. An analysis on the policy implemented by Chinese government through the dimensions of land and water to implement the strategy is conducted. While it is too early to evaluate the whole process of OBOR, China has been taking daring steps to meet the primary strategy of ensuring its energy security. At this rate, it is agreeable that probability of China ensuring its energy security out of control of U.S., nearly one or two decades.*

***Keywords:** Geopolitical Strategy, Energy Security, Chokepoints, “One Belt, One Road”*

* * *

XIII зуунд Их Монгол улсын засаглал дор даян дэлхий оршиж байсан тэр цаг үеийг “Pax Mongolica” буюу “Монголын Энх тайван” хэмээн түүхнээ тэмдэглэдэг. Их Монгол гүрэн өрнө, дорныг холбосон дэлхийн тээвэр, худалдааны гол дэд бүтэц торгоны замыг хяналтдаа байлгаж, удирдаж байв.

Их Монголын эзэнт гүрэн задарсны дараагаар дэлхийд далайн аян дайны үе эхэлж, Европын улсууд ээлж дараалан дэлхийн тавцнаа ноёлогч улс болон гарч ирсэн түүхтэй. Испани, Португаль, Франц, Англи гэх мэт олон улс шил шилээ даран хүчирхэгжин гарч ирж байсны дотор Их Монголын эзэнт гүрэнтэй дүйхүйц гүрэн улс нэгээхэн ч төрөөгүй юм. Харин, Дэлхийн II дайнаас (Д2Д) хойших 70 жилд дэлхийд ноёлогч байр суурьтай явж ирсэн АНУ-ыг даян дэлхийн дэг журмыг тогтоон ноёлж буйгаараа Чингисийн их гүрнээс хойш гарч ирсэн анхны дэлхийн хэмжээний ноёлогч гүрэн мөн гэж үздэг.¹⁵

Хүйтэн дайны үе багтаж байгаа хэдий ч Д2Д-аас хойших эдүгээ хүртэлх Америкийн ноёлж ирсэн цаг үеийг “Pax Americana” гэж нэрлэдэг. Гэтэл, өнөөдөр тэрхүү ноёлогч улсын хүчирхэг байр суурь илтэд суларч, Хятад хэмээх өрсөлдөгч гарч ирж байна. Дэлхийн түүхийг судалсан эрдэмтэд аливаа төрт улсад амьдралын цикл гэдэг ойлголт байдгийг тогтоожээ.¹⁶ Ялангуяа, ноёлогч улс хөгжлийнхөө жамаар оргил үедээ хүрээд тодорхой хугацааны дараа хүчин чадал нь суларч, байр сууриа алддаг зүй тогтолтой байдаг байна.

Ноёлогч улс үнэмлэхүй хүчирхэг байр сууриа алдах үйл явц аажмаар явагддаг байна. 1991 онд ЗХУ задарснаас хойш АНУ үнэмлэхүй ноёлогч байр суурийг

* МУИС, ОУХНУС-ийн ОУХ-ны тэнхимийн докторант

¹⁵ Brzezinski, Z. *The Grand Chessboard: American Primacy and its Geostrategic Imperatives*, 1st ed. New York: Basic Books Inc., 1997.


¹⁶ Kitano, Y. *The Methodology of Crymlya*, 1st ed. Tokyo: Shuei-sha Intl. Inc., 2014.

эзэлж эдүгээ хүрсэн боловч 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралаар тэрхүү хүчирхэг байр суурь нь суларч эхэлсэн юм. Харин, хямралын жилүүдэд 2008 оны Бээжингийн олимпоор эрчээ авсан Хятад улсын эдийн засгийн өсөлт жил бүр хоёр оронтой тоогоор хэмжигдэж, илт хүч аван гарч ирсэн юм.¹⁷

Тэрхүү эдийн засгийн өсөлт үргэлжилж байх үед Хятадын Коммунист намын дээд удирдлага солигдон Сы Зин Пин төрийн тэргүүн болж, 2013 оноос Шинэ торгоны зам төслийн концепцийг зарласан нь “Нэг бүс, Нэг зам” санаачилгын эхлэл байв. Хятад улсыг дахин мандуулна гэсэн агуулга бүхий “Хятад мөрөөдөл” хэмээх шинэ уриаг зарлан Сы Зин Пин томоохон далайцтай ажлуудыг дотоод, гадаад бодлогодоо хэрэгжүүлж эхэлсэн юм. Цөөнгүй судлаач Сы Зин Пиний бодлогыг АНУ-ын ноёлогч байр суурийг сулруулах зорилго өвөрлөж байна гэж үздэг.¹⁸

2013 онд Хятадын төрийн тэргүүн Сы Зин Пин Шинэ торгоны зам гэх концепцийг дэвшүүлсэн нь эдүгээ “Нэг бүс, нэг зам” нэртэй санаачилга болон өргөжөөд байна. 2017 оны 5 сард Бээжин хотноо болсон “Бүс, зам” форумд дэлхийн 130 орчим орны төлөөлөгч оролцож, 30-аад орны төрийн тэргүүн хүрэлцэн иржээ.

Дэлхийн хүн амын 60 хувь, эдийн засгийн гуравны нэгийг хамарсан асар том хэмжээний хүсэл зорилго агуулсан энэ санаачилгад Хятад улсын зүгээс 4 их наяд ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөжээ.



Зураг 1. “Нэг бүс, нэг зам” санаачилгын ерөнхий концепци

“Нэг бүс, нэг зам” санаачилга хоёр үндсэн хэсгээс бүрдэж байна (Зураг 1). Энэ нь Торгоны замын эдийн засгийн бүс, 21-р зууны далайн торгоны зам гэж

¹⁷ Kitano, Y. *The Methodology of Crymlya*, 1st ed. Tokyo: Shuei-sha Intl. Inc., 2014.

¹⁸ Lee Kuan Yew. *Lee Kuan Yew*, 1st ed. London: The MIT Press., 2013.

тус бүр нэрлэгдэж байна. Торгоны замын эдийн засгийн бүсэд Хятадын баруун бүс нутгаас эхлэн Төв Азиар дамжин Ойрхи Дорнод хүртэлх эх газрын бүс нутаг хамрагдана. Далайн торгоны замд Зүүн өмнөд Ази, Персийн булан, Африкийн хошууг оруулжээ.¹⁹

Зураг 1-д уг санаачилгын ерөнхий концепцийг үзүүлэв. Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор байгуулах үзэл санаа энэ санаачилгын хүрээнд яригдаж буй. Хэрэгжүүлэх ажил хараахан эхлээгүй байгаа боловч талуудын ойлголцол гүнзгийрч, ажил хэргийн уулзалт хэлэлцээрүүд амжилттай өрнөж байна.²⁰

“Нэг бүс, Нэг зам” санаачилга бол эрч хүчтэйгээр түрэн гарч ирж буй Хятад гүрний эдийн засгийн хөгжлийн зүй ёсны шаардлагаар урган гарч буй том зорилго юм. Энэхүү том санаачилга геополитикийн стратеги талаасаа улс орны хөгжлийн үндэс болсон эрчим хүчний хангамжийн найдвартай системийг бий болгох гэсэн анхдагч зорилго агуулж буй гэж дүгнэж буйтай судлаач санал нэгдэж байна. Тиймээс энэхүү стратегийн зорилтын хэрэгжилтийн явц эдүгээ ямар түвшинд байгааг тодорхойлохыг энэ судалгааны ажлын үндсэн зорилго болголоо.

Шинээр хүчирхэгжин гарч ирж буй Хятад улс эдүгээ дотооддоо эдийн засгийн цөөнгүй бэрхшээлтэй тулгарч байгаа ч гэлээ, эдийн засгийн өсөлт, тэлэлт нь үргэлжлэх төлөвтэй гэж судалгааны байгууллагууд үзэж байна. Нөхцөл байдал өнөөгийн эрчээрээ явбал 2035 он гэхэд тус улсын ДНБ 43.7 их наяд ам. долларт хүрч тухайн үед 26.7 их наяд ам.долларт хүрэх магадлалтай АНУ-ын ДНБ, ойролцоогоор 27.8 их наяд ам.доллар болох Европын холбооны ДНБ-ээс барагцаагаар 1.6 дахин том болж өсөх магадлалтай юм.²¹

Хятад улсын эрчим хүчний салбарын хөгжил

Аливаа улсын үндэсний эрх ашиг гэдэг ойлголтод нэн түрүүнд эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал хоёрыг авч үздэг. Эрчим хүчний хангамж бол эдийн засгийн хөгжлийн төдийгүй үндэсний аюулгүй байдлын суурь болдог бөгөөд энэ утгаараа үндэсний эрх ашгийг хангах түлхүүр хүчин зүйлсийн нэг юм. (Kitano) Орчин үеийн нийгмийн амьдралын бүхий л хүрээнд эрчим хүч чухал үүрэгтэй. Эрчим хүчний үнэ хямд төсөр, ханган нийлүүлэлт тасралтгүй байх нь эдийн засаг хөгжих суурь болж өгдөг.

Хятад улсын эдийн засаг сүүлийн хорин жилийн туршид үсрэнгүй хөгжиж, хэмжээ нь тэлэхийн хэрээр эрчим хүчний хэрэглээ огцом хурдаар өсөж ирлээ. 2008 онд АНУ-аас эхэлсэн дэлхийн эдийн засгийн хямралын үеэр Хятадын эдийн засаг жил бүр хоёр оронтой тоогоор өсжээ. Тухайлбал, 2008-2014 оны хооронд

¹⁹ “The State Council of the People’s Republic of China,” The Belt and Road Initiative, Accessed May 30, 2017, <http://english.gov.cn/beltAndRoad/>

²⁰ “The State Council of the People’s Republic of China,” The Belt and Road Initiative, Accessed May 30, 2017, <http://english.gov.cn/beltAndRoad/>

²¹ “The Diplomat,” Samir Tata, Accessed May 30, 2017, <http://thediplomat.com/2017/01/deconstructing-chinas-energy-security-strategy/>

тус улсын эрчим хүчний импортын хэмжээ даруй 60 гаруй хувиар нэмэгдэж газрын тосонд шилжүүлснээр 535.4 сая тоннд хүрчээ.²²

АНУ-ын эрчим хүчний мэдээллийн агентлагийн “Олон улсын эрчим хүчний төлөв-2016” баримт бичигт дурдсанаар Хятадын газрын тосны импорт 2015 онд өдрийн 6.6 сая баррель хүрсэн нь тус улсын газрын тосны нийт хэрэглээний 59 хувьтай тэнцүү ажээ. Дээрх агентлагийн тооцоолсон урьдчилсан таамгаар 2035 он гэхэд Хятадын газрын тосны импорт 9.7 сая баррель/өдөрт болж нийт хэрэглээний 62 хувийг эзлэх төлөвтэй байна.²³

Хятад улсын эрчим хүчний хангамж байгалийн хийн импортоос бас ихээхэн хамааралтай байдаг. Дээр дурдсан агентлагийн гаргасан статистикаас үзвэл 2015 онд байгалийн хийн импортын хэмжээ 1.4 их наяд куб метр (trillion cubic feet, Tcf) буюу нийт хэрэглээний 24 хувьтай тэнцэж байсан бол 2035 он гэхэд 6 их наяд куб метр болж, хэрэглээний зах зээлийн 26 хувьд хүрнэ гэж таамаглажээ. Мөнхүү агентлагийн үзэж буйгаар цаашид тус улсын газрын тосны импорт жилд 2 орчим хувиар өсөх бол байгалийн хийн импортын өсөлт түүнээс илүү хүчтэй болж ойролцоогоор 7.5 хувиар жил бүр өсөх магадлалтай байна.²⁴

Дэлхийн далайн тээвэр дэх АНУ-ын хяналт

Дэлхийн газрын тос, байгалийн хийн нийлүүлэлт, тээврийн сүлжээ үндсэндээ АНУ-ын бүрэн хяналтан дор байдаг талаар эх сурвалжууд^{25,26} мэдээлсэн байдаг. Өнөөдөр дэлхийн газрын тосны нийт хэрэглээний талаас илүү хувийг далайгаар тээвэрлэж байна. Түүхийн явцад далайн тээврийг хамгийн дөт байхаар оновчтой болгох үйл явц өрнөж, эдүгээ нэгэнт тогтсон олон улсын маршрут бий болжээ. Дэлхийн далайн тээврийн маршрутад 8 чухал дайран өнгөрөх зангилаа цэг (chokepoints) байдгийг *Зураг 2-т* үзүүлэв.²⁷

²² “International Energy Agency,” Accessed May 30, 2017, <https://www.iea.org/>


²³ “U.S. Energy Information Administration,” International Energy Outlook 2016, [https://www.eia.gov/outlooks/ieo/pdf/0484\(2016\).pdf](https://www.eia.gov/outlooks/ieo/pdf/0484(2016).pdf)

²⁴ “U.S. Energy Information Administration,” International Energy Outlook 2016, [https://www.eia.gov/outlooks/ieo/pdf/0484\(2016\).pdf](https://www.eia.gov/outlooks/ieo/pdf/0484(2016).pdf)

²⁵ “U.S. Energy Information Administration,” World oil transit chokepoints, Accessed May 30, 2017, <https://www.eia.gov/todayinenergy/detail.php?id=18991>

²⁶ “Business Insider,” Jeremy Bender, Accessed May 30, 2017, <http://www.businessinsider.com/worlds-eight-oil-chokepoints-2015-4>

²⁷ “U.S. Energy Information Administration,” World oil transit chokepoints, Accessed May 30, 2017, <https://www.eia.gov/todayinenergy/detail.php?id=18991>



Зураг 2. Дэлхийн газрын тосны тээврийн гол зангилаа цэгүүд. (Нэрийн ардах тоо нь тус цэгээр өдөрт дамжих газрын тосны хэмжээг сая баррелаар зааж буй.)

Тэдгээр нь Панамын суваг, Данийн хоолой, Боспорусын хоолой, Сүэцийн суваг, Баб Эл-Мандебын хоолой, Хормузын хоолой, Кэйп Таун, Малаккагийн хоолой гэсэн найман зангилаа цэг юм. Ойрхи Дорнодод байрлах Хормузын хоолой хамгийн чухал зангилаа цэг бөгөөд өдөрт 17 сая баррель газрын тосны тээврийг нэвтрүүлэн гаргадаг. Боспорусын хоолойгоор 2.9 сая баррель, Панамын сувгаар 0.85 сая баррель газрын тос тус тус нэг өдрийн дотор дайран өнгөрч байдаг.²⁸ Өнөөгийн байдлаар Хятад улсын газрын тос, байгалийн хийн нийлүүлэлтийн дийлэнх хэсэг Персийн булан, Африкаас хийгдэж байгаа нь Америкийн хяналтад байдаг зангилаа цэгүүдээс бүрэн хамааралтай байгаа хэрэг юм.

Хятад улсын эрчим хүчний аюулгүй байдлын стратеги

Хятад улс эрчим хүч, түүний дотор газрын тосны импортоос ихээхэн хамааралтай байдаг сул талаа нөхөх нь стратегийн чухал ач холбогдолтой юм. “Нэг бүс, нэг замд” тээврийн төслүүд томоохон байр суурь эзэлж буй мэт үзэгдэвч, үнэн хэрэгтээ Хятад улсын эрчим хүчний аюулгүй байдал энэ санаачилгад хамгийн чухал байр суурь эзэлж байна. 2015 онд тус улс нийт газрын тосны нийлүүлэлтийнхээ 60 хувийг импортоор авчээ. Энэ үзүүлэлт 2035 он гэхэд 80 хувьд хүрэх магадлалтай гэж таамаглаж байна.²⁹

Цагаас цагт өсөн нэмэгдсээр буй эрчим хүчний хэрэглээгээ хангах схемийг төрөлжүүлэх, ялангуяа импортын эрчим хүчний нийлүүлэлт, тээвэрлэлтийн

²⁸ “U.S. Energy Information Administration,” World oil transit chokepoints, Accessed May 30, 2017, <https://www.eia.gov/todayinenergy/detail.php?id=18991>

²⁹ “International Energy Agency,” Accessed May 30, 2017, <https://www.iea.org/>

аюулгүй байдлаа хангах нь Хятад улсын амин чухал эрх ашиг болж байна. Үүний тулд тэд ОХУ, Төв Ази, Иран гэх мэт бүс нутаг, улсуудтай эрчим хүчний хамтын ажиллагаагаа идэвхжүүлж байна. АНУ-ын хяналт дор байдаг олон улсын далайн тээврийн зангилаа цэгүүдээс ангид шинэ тээврийн зам нээх бодлого явуулж байна. Ялангуяа Өмнөд Хятадын тэнгис, Малаккагийн хоолойгоос хэт хамааралтай байдгаа саармагжуулах бодлогыг идэвхтэй хэрэгжүүлж байна. 2015 оны байдлаар Хятадын нийт газрын тосны импортын 83 хувь энэ хоёр зангилаа газраар дамжсан байна.^{30,31}

2003 онд тухайн үеийн Хятадын ерөнхийлөгч Ху Жинтао Энэтхэгийн далай, Номхон далайг холбон Индонези, Малайз, Сингапурын дунд орших Малаккагийн хоолойгоор Хятадын газрын тосны импортын 80 гаруй хувь дамжин өнгөрч буй хэт хамааралт байдлыг тодорхойлон хэлэхдээ “Малаккагийн ацан шалаа” гэх нэр томъёог анхлан хэрэглэжээ. Малаккагийн ацан шалаанаас гарах нь Хятадын эрх баригчдын тулгамдсан зорилтын нэг юм. “Нэг бүс, нэг зам” санаачилгын хүрээнд эрчим хүчний аюулгүй байдлаа хангахаар Хятадын засгийн газраас санаачлан явуулж буй үйл ажиллагааг голлох бүс нутаг, улс тус бүрээр авч үзье.

Төв Ази

Хятад улс Төв Азийн орнуудтай эдийн засгийн маш нягт хамтын ажиллагаа өрнүүлж байна. 2013 онд гэхэд Казахстан, Киргиз, Тажикистан, Туркменистантай хийсэн нийт худалдаа эргэлт 50 тэрбум ам.долларт хүрчээ. Зам, гүүр гэхчлэн дэд бүтцийн салбарт Төв Азийн орнуудад Хятадын компаниуд идэвхтэй хөрөнгө оруулж байна. Мөн эрчим хүчний салбарт маш идэвхтэй хөрөнгө оруулалт хийж байна. Казахстаны газрын тосны үйлдвэрлэлийн наанадаж дөрөвний нэгийг хятадууд эзэмших болжээ. Туркменистаны байгалийн хийн экспортын тал хувь нь Хятад руу чиглэж байна. Узбекистантай уран, байгалийн хийн салбарт 15 тэрбум ам.долларын гэрээ хийгээд байна.

2000-аад оны эхээр эхэлсэн Төв Азиас Хятад руу чиглэсэн байгалийн хийн хоолой татах санаачилгын хүрээнд эдүгээ 4 дэх шугам баригдаж байна. Хятадын хөрөнгө оруулалтаар барьсан, нийт 7.3 тэрбум ам.долларын өртөг бүхий 3,666 км үргэлжлэх Төв Ази-Хятадын хийн хоолой 2009 онд ашиглалтад орсон ба Туркменистан, Узбекистаны хилээс Хятадын Жингбаод хүрдэг. Эдгээр гурван улсыг дамнан Хятад руу орсон нийт гурван шугам бүхий (А, В, С) систем ашиглагдаж байгаа бөгөөд дахин шинээр нэг шугам нээж Тажикстан, Киргизстаныг холбохоор төлөвлөж буй.

Хятад 2013 оны 9 дүгээр сард Узбекистан, Тажикстан, Кыргызстантай Төв Ази-Хятадын 4 дэх хийн шугамыг барих гэрээг үзэглэсэн юм. Үүнийг D шугам гэж

³⁰ “International Energy Agency,” Accessed May 30, 2017, <https://www.iea.org/>

³¹ “U.S. Energy Information Administration,” International Energy Outlook 2016, [https://www.eia.gov/outlooks/ieo/pdf/0484\(2016\).pdf](https://www.eia.gov/outlooks/ieo/pdf/0484(2016).pdf)

нэрлэж буй бөгөөд Туркменистаны Хятад руу чиглэсэн хийн экспортыг 60 орчим хувиар өсгөх юм.^{32,33}

ОХУ

ОХУ 2015 оноос Хятадын хамгийн том газрын тос нийлүүлэгч болжээ. 10-аад жилийн өмнө Саудын Араб Хятадын газрын тосны нийт импортын 20 хувийг нийлүүлж, ОХУ дөнгөж 7 хувьтай байсан бол өнөөдөр тэр төрөл эрс өөрчлөгдөөд байна. ОХУ газрын тосны экспортоо тийнхүү хурдтай өсгөж чадсаны гол нууц бол Хятадын юанаар наймаалцаж байгаа явдал юм. Энэ нь Орос, Хятад хоёр улс петродоллар системийн эсрэг нэгдмэл байр суурьтай байдагтай холбоотой.

Хятад руу чиглэсэн Оросын эрчим хүчний экспортын гол тээвэр Зүүн Сибирь-Номхон далайн газрын тосны хоолой (East Siberia-Pacific Ocean, ESPO), “Сибирийн эрчим хүч” хийн хоолойгоор (Power of Siberia, POS) явагдаж байна. Эдгээр хоолойн хүчин чадлыг 2020 он гэхэд тус тус харгалзуулан 2.6 сая баррель/өдөр, 3.3 куб шоо метрт хүргэхээр төлөвлөжээ. 2035 оны Хятадын импортын хэрэгцээг хангах хэмжээнд хүрэхийн тулд ESPO хоолойн хүчин чадал өнөөгийнхөөс 4 дахин өсөж 10.4 сая баррель/өдөр, POS хоолойн хүчин чадал өнөөгийнхөөс 2 дахин өсөж 6.6 их наяд куб метрт хүрэх шаардлагатай юм.

2035 он гэхэд Орос улс Хятадын газрын тосны импортын 85 хувийг дангаараа нийлүүлж чадах хэмжээнд очих боломжтой. Магадгүй, 100 хувь хангах хэмжээнд ч хүрч мэднэ. Энэ хоёр улс эх газраар 4,179 км хиллэдэг бөгөөд Зүүн Хойд Хятадыг газрын тос, хийн хоолойгоор холбож нийлүүлэлтийг өсгөж чадвал АНУ-аас эмээх шаардлагагүй болно.^{34,35}

Пакистан

Хятад улс “Нэг бүс, нэг зам” санаачилгын хүрээнд Пакистантай харилцах хамтын ажиллагаанд өндөр ач холбогдол өгч буй бөгөөд Хятад-Пакистаны эдийн засгийн коридор төслийг хэрэгжүүлэхээр 2013 оны 5 сард зарласан юм. Пакистаны Гвадар боомтыг Шинжаантай холбосон авто зам, төмөр зам, газрын тос, хийн хоолой барих төслүүдийг төлөвлөөд байна. Гвадар боомтод хөрөнгө оруулах нь Хятадад стратегийн хувьд нэн чухал. Пакистан эрчим хүчээр хомс улс тул эдийн засгийн коридор төслийн дотоодын эдийн засагт үзүүлэх нөлөө өндөр. Хэдий тийм ч урт хугацаандаа уг төсөл тус улсын эдийн засагт ямар нөлөө үзүүлэх нь тодорхойгүй, үүнээс улбаалаад дотооддоо нэлээд маргаан дагуулж мэдэхээр шинжтэй байна. Гвадар боомтоос Хятадын Кашгар хүртэл 2000 км орчим хийн хоолой, автозам барихаар төлөвлөжээ.

Пакистаны Гвадар боомтод болон бусад дэд бүтцэд оруулж буй Хятадын хөрөнгө оруулалтын хэмжээ тус улсын жижигхэн эдийн засгийн хүчин чадлаас

³² “International Energy Agency,” Accessed May 30, 2017, <https://www.iea.org/>

³³ “U.S. Energy Information Administration,” International Energy Outlook 2016, [https://www.eia.gov/outlooks/ieo/pdf/0484\(2016\).pdf](https://www.eia.gov/outlooks/ieo/pdf/0484(2016).pdf)

³⁴ “International Energy Agency,” Accessed May 30, 2017, <https://www.iea.org/>

³⁵ “U.S. Energy Information Administration,” International Energy Outlook 2016, [https://www.eia.gov/outlooks/ieo/pdf/0484\(2016\).pdf](https://www.eia.gov/outlooks/ieo/pdf/0484(2016).pdf)

хамаагүй давж гарахаар шинжтэй байгаа нь орон нутгийн эрх баригчид, олон нийтийн санааг зовоож байна. Хятад улсын зүгээс Пакистанд стратегийн өндөр ач холбогдол өгч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй эдийн засгийн коридор төсөл ийнхүү орон нутгийн засгийн газрыг ацан шалаанд оруулж байна. Пакистаны эдийн засаг жилдээ дээд тал нь 2 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шингээх хүчин чадалтай гэж үзвэл Хятад улс 1 тэрбум ам.доллар давсан хөрөнгө оруулах нь зохимжгүй юм гэх байр суурь ч байна.^{36,37}

Мьянмар

Бенгалийн булан дахь Мьянмарын боомтыг Хятадын Юннан мужтай холбосон газрын тос, хийн хоолой ашиглалтад орсон. Ингэснээр Малаккагийн хоолойгоор дамжуулалгүй, дөт замаар эрчим хүчээ хангах боломжийг Хятадын тал олж авч буй хэрэг юм. Малаккагийн ацан шалаанаас гарахад стратегийн хувьд чухал ач холбогдолтой Мьянмар улсад хэрэгжүүлж буй зарим төслүүд орон нутгийнхны болон байгаль хамгаалах хөдөлгөөний эсэргүүцлээс улбаалан хэрэгжилт удааширч буй ажээ. Олон жил цэргийн дэглэмтэй байхдаа Хятадын найдвартай түнш улс явж ирсэн Мьянмар улс эдүгээ ардчиллын замаар замнаж эхэлсэн нь Хятадын талд хүндрэл учирч байна. Энэ байдал Пакистан дахь стратегийн хамтын ажиллагааны ач холбогдлыг улам өргөж байна.^{38,39}

Иран

ОХУ эрчим хүчний экспортоо Хятадаас хэт хамааралтай болгохгүйн тулд Европын Холбоотой харилцаагаа хүчтэй байлгахыг зорьж буйтай нэгэн адилаар Хятадууд импортын нийлүүлэлтээ төрөлжүүлэхийг зорьж байгаа нь ойлгомжтой. Энэ зорилтоо хэрэгжүүлэхэд Иран тэдний хувьд хамгийн тохиромжтой хамтрагч байх боломжтой. АНУ-ын хяналтад ороогүй улс гэдэг утгаараа ч бас өндөр ач холбогдолтой юм.

АНУ-ын Эрчим хүчний мэдээллийн агентлагийн (EIA) мэдээлснээс үзвэл 2015 оны байдлаар Иран 158 тэрбум баррель газрын тосны нөөцтэй байгаа нь Венесуэл, Саудын Араб, Канадын дараа дэлхийд 4-р байранд орж байна. 2014 оны байдлаар Ираны засгийн газрын орлогын 46 хувийг газрын тос, хийн экспортын орлого эзэлж байна (IMF). Тиймээс, Ираны хувьд эдийн засгийн аюулгүй байдлаа хангахад Хятадтай үүсгэх эрчим хүчний хамтын ажиллагаа чухал үүрэгтэй. Иран улс Пакистаны баруун өмнөд хэсгээр хил залгаа оршдог бол Хятад Пакистаны

³⁶ “International Energy Agency,” Accessed May 30, 2017, <https://www.iea.org/>

³⁷ Мөн тэнд

³⁸ “International Energy Agency,” Accessed May 30, 2017, <https://www.iea.org/>

“U.S. Energy Information Administration,” International Energy Outlook 2016, [https://www.eia.gov/outlooks/ieo/pdf/0484\(2016\).pdf](https://www.eia.gov/outlooks/ieo/pdf/0484(2016).pdf)

³⁹ Мөн тэнд

баруун хойд хэсгээр хиллэдэг. Тиймээс Пакистаны газар нутгаар дамжуулан тавих Хятад-Ираны хий, газрын тосны хоолой стратегийн өндөр ач холбогдолтой юм.

“Сувд хэлхэх” стратеги буюу далайн тээврийн шинэ зам

Хятад улсын эрчим хүчний аюулгүй байдлаа хангах стратегийн хүрээнд далайн цэргийн хүчээ нэмэгдүүлэх шаардлага үүсэж байна. Энэ талаар АНУ-ын Батлан хамгаалах хэлтсийн тайланд авч үзэхдээ Хятад улс “Сувдан хэлхээс” үүсгэх геополитикийн стратеги хэрэгжүүлж байна гэж анхлан мэдэгдсэн байдаг. Энэ нэр томъёог Хятадын тал огт хэрэглэдэггүй, АНУ, Япон, Энэтхэгийн хэвлэл мэдээллээр цөөнгүй гарч байдаг.⁴⁰

Аливаа улс усан цэргийн хүчин чадлаа өндөржүүлэх төдийгөөр далайн орон зайд үзүүлэх цэргийн хүчин чадлаа өсгөж чадахгүй гэж үздэг. Хятад улс бол түүхэн талаасаа далайн улс (sea power) биш, эх газрын (land power) улс юм. Далай дахь нөлөөллөө нэмэгдүүлэхийн тулд усан цэргийн тоо, хүчин чадлаа зузаатгах төдийд хангалттай биш байдаг. Учир нь өргөн уужим далайн орон зайд цэргийн үйл ажиллагаа явуулахын тулд тухайн улс өөрийн холбоотон улсуудынхаа боомтыг ашиглан шатахуун, хүнс зэрэг төрөл бүрийн хангалтуудаа авах боломжтой байх ёстой ажээ. Их Британийн эзэнт гүрэн далайн гүрний сонгомол жишээ байсан бөгөөд дэлхийн бүх далайд өөрийн хяналтын боомтуудтай байсан юм. Тиймээс, Хятад улс Америкийн цэргийн хяналт дор байдаг далайн тээврийн замаас тусдаа шинэ зам нээх гэдэг сорилтоо хэрэгжүүлэхийн тулд юун түрүүнд өөрийн гэсэн холбоотон, боомтуудын сүлжээг бий болгох шаардлагатай юм. Хятад улс Энэтхэгийн далайд тийм бодлого хэрэгжүүлж буйг АНУ-ын зүгээс тийнхүү “Сувд хэлхэх” стратеги хэрэгжүүлж байна гэж дүгнэсэн байна.⁴¹

Сувд хэлхэх бодлогын хэрэгжилтийн жишээнд Мьянмар, Пакистанд Хятадын зүгээс явуулж буй хамтын ажиллагааг оруулж болох юм. Мөн, Хятад улсын зүгээс Шри Ланкын хоёр ч боомтод ихээхэн хөрөнгө, хүч хаяж байгаа нь тэрхүү бодлогын хэрэгжилт мөн биз ээ. Хэдийгээр Хятадын засгийн газраас цэргийн зориулалтаар ашиглахгүй, зөвхөн иргэний зориулалтаар ашиглана гэж мэдэгдэж байгаа ч Шри Ланкын боомтод жил гаруйн өмнө цэргийн шумбагч онгоц нэгэнтээ ирж байрласан нь олон нийтийн анхаарлыг зүй ёсоор татаж байсан юм.⁴²

⁴⁰ “The Washington Times,” China builds up strategic sea lanes, Accessed May 30, 2017, <http://www.washingtontimes.com/news/2005/jan/17/20050117-115550-1929r/>

⁴¹ Luttwak, E. *China 4.0*, 1st ed. Tokyo: Bungei-Shunju, Inc., 2016.

⁴² “The Washington Times,” China builds up strategic sea lanes, Accessed May 30, 2017, <http://www.washingtontimes.com/news/2005/jan/17/20050117-115550-1929r/>

ДҮГНЭЛТ

“Нэг бус, нэг зам” санаачилгын хүрээнд эрчим хүчний нийлүүлэлт, тээврийн аюулгүй байдлаа хангах бодлогыг Хятад улс идэвхтэй авч хэрэгжүүлж байгаад шинжилгээ хийлээ. Эрчим хүчний нийлүүлэлтээ төрөлжүүлэх, АНУ-ын хяналт дор байдаг далайн тээврийн холболтын тэнгисийн замуудаас (sea lines of communication, SLOCs) ангид тээврийн шинэ маршрут нээх талаар идэвхтэй бодлого явуулж байна. ОХУ, Казахстанас түүхий газрын тос дамжуулах хоолойг ашиглалтад оруулж, цаашид өргөжүүлэх бодлого барьж байгаа нь эрчим хүчний хангамжийн эх газрын шугамууд нээхэд ач холбогдол өгч буйг илтгэж байна. Малаккагийн ацан шалаанаас гарахад чухал үүрэг гүйцэтгэх Мьянмар-Хятадын хоолойг 2015 онд ашиглалтад оруулсан нь Ойрхи Дорнод, Африкаас импортлох газрын тосыг шинэ замаар тээвэрлэх стратегийн чухал ач холбогдолтой ажил болжээ. ОХУ маш богино хугацаанд Хятадын хамгийн том газрын тос нийлүүлэгч болсон нь энэ хоёр улс худалдааны гэрээгээ ам.доллараар биш, юанаар хийж байгаатай шууд холбоотой юм. Энэ үйл ажиллагаа нь өнөө хүртэл оршиж ирсэн АНУ-ын ноёрхлын илэрхийлэл болсон петродоллар системийн эсрэг байдгийг илтгэнэ.

Ийнхүү Хятад улс эрчим хүчний аюулгүй байдлаа хангахаар явуулж буй идэвхтэй бодлого үр дүнд хүрч байгаа ч тус улсын цагаас цагт хурдтай өсөн нэмэгдэж буй хэрэглээг тооцоолж үзвэл тийм ч богино хугацаанд Америкийн хяналтаас гадуур эрчим хүчний аюулгүй байдлаа хангаж чадахааргүй байна. Гэвч, одоогоос 20 жилийн дараа Хятад улс эрчим хүчний хувьд хараат бус болж чадах магадлал өндөр гэж зарим мэргэжилтнүүд үзэж буйтай⁴³ санал нэг байна.

⁴³ “The Diplomat,” Samir Tata, Accessed May 30, 2017, <http://thediplomat.com/2017/01/deconstructing-chinas-energy-security-strategy/>

НОМ ЗҮЙ

1. Brzezinski, Z. *The Grand Chessboard: American Primacy and its Geostrategic Imperatives*, 1st ed. New York: Basic Books Inc., 1997.
2. Katusa, M. *The Colder War: How the Global Energy Trade Slipped from America's Grasp*, 1st ed. New Jersey: John Wiley & Sons, Inc., 2015.
3. Kitano, Y. *The Methodology of Crymlya*, 1st ed. (in japanese). Tokyo: Shuei-sha Intl. Inc., 2014.
4. Lee Kuan Yew. *Lee Kuan Yew*, 1st ed. London: The MIT Press., 2013.
5. Luttwak, E. *China 4.0*, 1st ed. (in japanese). Tokyo: Bungei-Shunju, Inc., 2016.

Вэб сайт:

1. “Business Insider, ” Jeremy Bender, Accessed May 30, 2017, <http://www.businessinsider.com/worlds-eight-oil-chokepoints-2015-4>
2. “Business Insider,” Elena Holodny, Accessed May 30, 2017, <http://www.businessinsider.com/russia-vs-saudi-arabia-in-chinas-oil-market-2016-2>
3. “Center for International Maritime Security,” *Vidya Sagar Reddy*, Accessed May 30, 2017, <http://cimsec.org/reinforcing-chinas-malacca-dilemma/28117>
4. “International Energy Agency,” Accessed May 30, 2017, <https://www.iea.org/>
5. “U.S. Energy Information Administration,” Accessed May 30, 2017, <http://www.eia.gov>
6. “U.S. Energy Information Administration,” International Energy Outlook 2016, [https://www.eia.gov/outlooks/ieo/pdf/0484\(2016\).pdf](https://www.eia.gov/outlooks/ieo/pdf/0484(2016).pdf)
7. “U.S. Energy Information Administration,” World oil transit chokepoints, Accessed May 30, 2017, <https://www.eia.gov/todayinenergy/detail.php?id=18991>
8. “The Diplomat,” Samir Tata, Accessed May 30, 2017 , <http://thediplomat.com/2017/01/deconstructing-chinas-energy-security-strategy/>
9. “The State Council of the People's Republic of China,” The Belt and Road Initiative, Accessed May 30, 2017, <http://english.gov.cn/beltAndRoad/>
10. “The Washington Times,” China builds up strategic sea lanes, Accessed May 30, 2017, <http://www.washingtontimes.com/news/2005/jan/17/20050117-115550-1929r/>